**УЛААНБААТАР**
**ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ**

# ТОГТООЛ

1984 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Хотын архитектур төлөвлөлтийн газарт мөрдөх жагсаалтын дүрэм батлах тухай

*1986 оны 205-р тогтоолоор хүчингүй.*

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.БНМАУ-ын Хөдөлмөр Цалин Хөлсний Улсын Хороо, ШУЗ-ийн 1978 оны 58/38 дугаар тогтоолыг үндэслэн боловсруулсан хотын Архитектур төлөвлөлтийн газарт мөрдөгдөх жагсаалтын дүрмийг хавсралтын дагуу баталж, 1984 оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөхийг Архитектур төлөвлөлтийн газарт зөвшөөрсүгэй.

2.Засварын зураг төсөв боловсруулах ажлын хугацааны нормыг 1984 оны 12 дугаар сарын 1-ний дотор шинээр боловсруулан баталж хэрэгжүүлсний үндсэн дээр жагсаалтын дүрмийг мөрдөхийг хотын Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т даалгасугай.

3.Хотын төлөвлөгөөний комисс /н.Ганбаатар/, Их барилгын хэлтэс /н.Гомбо/-т ДААЛГАХ нь:

а/Архитектур төлөвлөлтийн газрын зураг төсөв зохиох нэр төрлийн төлөвлөгөөг үндэслэл сайтай боловсруулж төлөвлөгөөт оны I дүгээр сард багтаан баталж өгч байсугай.

б/Нэр төрлийн төлөвлөгөөнд нэмж ажил тусгах, хасах зэрэг төлөвлөгөөний зохицуулалтыг тухай бүр нь хийж байсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА [illegible].ЭНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ

Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1984 оны
II дугаар сарын 30-ний өдрийн хурлын 192-р
тогтоолоор БАТЛАВ.

## ХОТЫН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ МӨРДӨХ ШАГНАЛЫН ДҮРЭМ

### Нэг. Үйлдвэрлэлийн инженер техникийн ажилтан, ажилчдын шагнал

Шинээр баригдах, өргөтгөх болон засварлагдах барилга байгууламж, тохижилт, гэрлэн чимэглэлийн зураг төсвийг **хугацаанд нь** чанартай боловсруулах, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийн байршилтыг оновчтой зөв шийдвэрлэхэд инженер техникийн ажилтан, ажилчдын материаллаг сонирхлыг өрнүүлэх зорилгоор шагналыг олгоно.

#### А. Зураг төсвийг чанартай боловсруулсанд олгох шагнал.

1. Тухайн улиралд гүйцэтгэсэн нийт зураг төсвийн ажил нь хугацаандаа чанарын өндөр түвшинд боловсруулагдаж, ажлын чанарын үнэлгээ нь "Согоггүй зураг төсөв боловсруулах систем"-ийн дагуу 0,76-аас доошгүй байгаа нөхцөлд зураг төсөв зохиогчдод улирал бүр албан тушаалын сарын цалингийн 10 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

2. Зураг төсвөөр дамжуулан шинэ бүтээц хэрэглэж барилга угсралтын ажлыг хялбарчлах, орон нутгийн хямд материал хэрэглэх засварын төсөвт буцах материал тусгах замаар барилгын төсөвт өртгийг хямдруулсан байвал зураг төсөв зохиогчдод улиралд албан тушаалын сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

3. Улаанбаатар, түүний дагуул хотуудын дэвсгэрт баригдах бүх төрлийн барилга байгууламжуудад газар олгох асуудлыг үндэслэл сайтай, чанартай боловсруулж шийдвэрлэх, гадаад дотоодын зураг төслийн байгууллагуудад боловсруулагдсан төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг хянан зөвшөөрөлцөх, бүх төрлийн инженерийн

хангамжийн техникийн нөхцлийг хянах зардаар зураг төсвийн ажлыг эхлэх урьдчилсан нөхцлийг хангаж буй газар олголт, улаан шугамын тасгийн инженер, архитекторуудад албан тушаалын сарын цалингийн 10 хүртэл хувиар бодож улирал бүр шагнал олгоно.

Б. Зураг төсөв боловсруулах хугацааг хорогдуулсанд олгох шагнал.

4. Хотын төлөвлөгөөний комиссоор батлагдсан нэр төрлийн төлөвлөгөө, графикаар өгөгдсөн ажлуудыг чанартай зохиож, нормативт хугацааг /хугацааны нормыг үндэслэж тогтоосон/ хорогдуулан гүйцэтгэсэн ажилтан, ажилчдад хугацаа хорогдуулсаны шагналыг хорогдуулсан хугацаанд ноогдох албан тушаалын цалингаас норматив хугацаанд эзлэх хувиар бодож олгоно.

5. Хариуцсан групп / тасгийн хэмжээгээр улиралд хийгдвэл зохих зураг, төсөв 100 хувь хугацаандаа буюу хугацааны өмнө чанарын шаардлага хангаж иж бүрэн боловсруулагдсан байвал групп, тасгийн дарга нарт улиралд сарын цалингийн 20 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

6. Чанарын шагнал олгогдсон объектын зураг төслийг хэрэгжүүлэх явцад техникийн алдаа илэрвэл зөрчил илэрсэн улиралд тухайн зураг төслийг зохиогчид чанарын шагнал олгохгүй.

Хоёр: Газрын удирдах инженер, техникийн ажилтан, ажилчид. Туслах үйлдвэрийн ажилтан, ажилчдын шагнал.

7. Хотын архитектур төлөвлөлтийн газрын дарга, ерөнхий инженер, ахлах ня-бо нарт борлуулалт, ашиг, нэр төрлийн төлөвлөгөөг биелүүлсэн нөхцөлд эхний хагас жил, жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний үнийн дүнгээр биелэлтээр доор дурьдсан хэмжээгээр шагнал олгоно.

| | Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт хувиар | Сарын цалингаас олгох шагналын хэмжээ |
|---|---|---|
| Архитектур төлөвлөлтийн газар | 100-110 хүртэл | 40 хүртэл хувь |
| | 110-аас дээш | 50 хүртэл хувь |

8. Групп, тасгийн дарга нарт жэр төрлийн төлөвлөгөөг баталсан графикийн дагуу биелүүлж, зураг төсвийг чанартай гаргаж дараагийн шат дамжлагад хугацаанд нь бүрэн шилжүүлсэн нөхцөлд үйлдвэрлэлийн хагас жилийн, жилийн төлөвлөгөөний / үнийн дүнгээр биелэлтээр дараах шагнал олгоно.

| Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт / хувиар / | Сарын цалингаас олгох шагналын хэмжээ |
|---|---|
| 100-110 хүртэл | 30 хүртэл хувь |
| 110-аас дээш | 40 хүртэл хувь |

9. Жэр төрөл, аж ахуйн гэрээгээр ажлууд хугацаандаа бүрэн хийгдсэн, зураг, төсөв боловсруулах техникийн баримт бичгийн бүрдүүлэлт сайжирсан нөхцөлд гэрээ захиалга хариуцсан мэргэжилтэнд эхний хагас жил, жилээр албан тушаалын сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

10. Байгууллагын эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийн /үйлдвэрлэл, ашиг, зардал, ХБ/ төлөвлөгөө биелсэн нөхцөлд эдийн засагчид албан тушаалын сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож эхний хагас жил, жилээр шагнал олгоно.

11. Эхний хагас жил, жилийн борлуулалтын төлөвлөгөөг биелүүлсэн зураг төсөв олгогчид албан тушаалын сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

12. Улирлын төлөвлөгөөг биелүүлсний шагналд хамаарагдаагүй туслах үйлдвэрлэл, захиргааны зарим тэргүүний ажилтан, ажилчдад захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооноос зөвшөөрөлцсөний үндсэн дээр хагас жил, бүтэн жилээр тэдний албан тушаалын сарын цалингийн 10 хүртэл хувиар шагнал олгоно.

Гурав. <u>Шагналын эх үүсвэр, шагнал олгох журам</u>

13. Үйлдвэрлэлийн ИТА, ажилчдын шагналын фондыг тэдний жилийн цалингийн фондын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр бодож газрын жилийн цалингийн фондод оруулж батлуулна.

14. Удирдах ИТА, туслах үйлдвэрийн ажилтан ажилчдын шагналын хөрөнгийг байгууллагын үйлдвэрийн үндсээс гаргана.

15. Үйлдвэрлэлийн ИТА, ажилчдын шагналын дээд хэмжээ нь зураг төсөв зохиох хугацаанд ноогдох албан тушаалын цалингийн 30 хувь, удирдах ИТА нарт жилд олгох шагналын дээд хэмжээ нь тэдний алсан тушаалын нэг сарын цалингаас хэтэрч үл болно.

16. Зураг төсвийг чанартай боловсруулсан, хугацааг хорогдуулсанд олгох шагналын хувь хэмжээг үйлдвэрчний эвлэлийн хороотой зөвшилцсөний үндсэн дээр газрын хариуцлагатны зөвлөлгөөнөөр тогтоож батална.

17. Газрын дарга, ахлах ин-ер нарт олгох шагналыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны захирамжаар ерөнхий инженер, тасгийн дарга нар, гэрээ захиалга хариуцсан мэргэжилтэн, эдийн засагч болон бусад ИТА, ажилчдын шагналыг газрын даргын тушаалаар батална.

18. Үйлдвэрлэлийн ажиллагаанд зөрчил гаргасан, хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн ажилтан ажилчдын шагналыг хасах буюу бууруулах эрхийг газрын дарга, ерөнхий инженер эдлэх бөгөөд шалтгааныг хариуцлагатны зөвлөлгөөний протоколд тодорхой заасан байвал зохино.

19. Зураг төсвийг хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлэн гүйцэтгэх, төлөвлөгөөг тасалдуулсан ажилтан, ажилчдын цалинг төлөвлөгөөний тасарсан хувьтай харьцаагаар бууруулан олгох **гахдаа** алсан тушаалын цалингийн 15 хувиас хэтэрч үл болно.